

**АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫГ ХӨГЖҮҮЛЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,  
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

**2020 оны жилийн эцэс**

Д/д	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2020 оны зорилгот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	Хэрэгжилтийн хувь
4.1. Салбарын хөгжлийг хангах эрх зүйн орчинг үйлчилгээний чанар, аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгох зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.						
1	4.1.3. Ахуйн үйлчилгээний ангилал тус бүрээр мөрдөгдөх стандартыг олон улсын стандартад нийцүүлэн шинээр болон шинэчлэн боловсруулж, мөрдүүлэх;	2020 - 2024	улсын төсөв-7.98 сая.төг		Салбарын хүрээнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны А-362 тоот тушаалаар Ахуйн үйлчилгээний салбарын стандартыг шинэчлэх болон шинээр боловсруулах ажлын хэсгийг батлуулсан. Ажлын хэсгийн хүрээнд стандартыг төслүүдийг боловсруулсан Нийтлэг үйлчилгээний техникийн хороогоор хэлэлцэж Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ. Үс засах үйлчилгээнд тавих шаардлага MNS 5160:2020, Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ. Оршуулгад хамаарах үйлчилгээ. Ерөнхий шаардлага MNS 6841:2020 стандартыг, Гоо сайхны техникийн хороогоор Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ. Хумс заслын үйлчилгээ. Ерөнхий шаардлага MNS 6843:2020 стандартуудын төслийг хэлэлцүүлэн тус тус батлуулав.	100%
2	4.1.4. Ажиллагсдын ур чадварын зэрэглэл тогтоох эрх зүйн үндсийг бий болгох;	2020 - 2024	улсын төсөв-0,7 сая төг		1. Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, Германы хамтын ажиллагааны нийгэмлэгийн “Түншлэлд суурилсан техникийн болон мэргэжлийн боловсрол сургалт” төсөл, Эрчим хүчний хөгжлийн төв, “Хамгаалалтын байгууллагуудын холбоо” ТББ, Тогтвортой ноос ноолуурын эвсэл, Үсчин гоо сайханчдын холбоо болон Төв аймгийн Эрдэнэ МСҮТ-тэй хамтран эдийн засгийн 7 салбарын 20 мэргэжлийн ажил мэргэжлийн лавлахыг боловсруулсан. Тус “Ажил мэргэжлийн лавлах”-ыг Мэргэжлийн боловсрол, сургалтын Үндэсний зөвлөлийн 2020 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн ХНХ-ын сайдын 01 тоот	70%

				тушаалаар баталлаа. Энэхүү ажил мэргэжлийн лавлах нь ХНХЯ-ны дэргэд байгуулсан Мэргэжлийн зөвлөлөөс мэргэжилтэй ажилтны ур чадварын түвшинг тогтоох эрх зүйн үндсэн баримт бичиг бөгөөд үйлчилгээ эрхлэгчдийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, үйлчилгээний чанарыг сайжруулахад чухал үүрэг гүйцэтгэх юм. 2. Ахуйн үйлчилгээний салбарын мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагаар бэлтгэх мэргэжлийн нэр, индексийг шинэчлэн боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Жижиг, дунд үйлдвэрийн газрын даргын А/16 тоот тушаалаар батлуулав. Тус ажлын хүрээнд салбарын хэмжээнд нийт 21 ажил, мэргэжлийг шинээр болон шинэчлэх саналыг боловсруулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого зохицуулалтын газраар дамжуулан ХНХЯ-нд хүргүүлж холбогдох тайлбарыг гаргаж ажиллав.	
3	4.1.5. Ахуйн үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийг үе шаттайгаар ангилж, зэрэглэх;	2020 - 2024	-	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба болон Монголын Үсчин, гоо сайханчдын холбоо, мэргэжлийн зөвлөлтэй хамтран үсчний салбарт технологийн түвшний үнэлгээ хийхээр Хамтран ажиллах гэрээний төсөл боловсруулан удирдамж батлуулахаар ажилласан боловч Дэлхий дахинд үүсээд буй цар тахлын улмаас тус арга хэмжээ хойшлогдсон.	70%
4.2. Бүс, орон нутгийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан ахуйн үйлчилгээний төвийг улс, орон нутгийн төсөв болон төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулах зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.					
4	4.2.1. Ахуйн үйлчилгээний зориулалтаар ашиглаж болох нийслэл, орон нутгийн өмчлөлд байгаа барилга байгууламжийг үйлчилгээ эрхлэгчдэд ашиглуулах	2020 - 2024	орон нутгийн төсөв-257.9 сая.төг гадаад төсөл-50.0 сая.төг	Улсын хэмжээнд ашиглагдахгүй байгаа 8 орон нутгийн өмчид 104 сая төгрөгийн засвар, үйлчилгээ хийж ахуйн үйлчилгээний чиглэлээр үйлчилгээ эрхлэгч нарт ашиглуулж байна. Аймаг тус бүрээр авч үзвэл: • Улаанбаатар хотод ашиглагдахгүй байгаа халуун усны төвийг дахин ашиглах ажлын хүрээнд “Нийтийн ахуйн үйлчилгээний төв” төслийн эхний төвийг Чингэлтэй дүүргийн 17-р хорооны нутаг дэвсгэрт барихаар шийдвэрлэж, газар эзэмших эрхийн гэрчилгээг авсан. Төслийн үйл ажиллагаа цар тахлын улмаас тодорхойгүй хугацаагаар хойшлогдоод байна. • Баянхонгор аймаг шинээр ашиглалтад орсон Ахуйн үйлчилгээний төвд 20 аж ахуй нэгж, иргэдэд түрээслүүлдэг бөгөөд 2020 оны 04 сараас 12 дугаар сарын 31 хүртэл 1,2 давхар 1 кв талбай нь 8800, В1 давхар нь 1 кв талбай нь 6600 төгрөгөөр болгож түрээсийн хөнгөлөлт үзүүлэн дэмжин ажилласан. • Дорнод аймагт Зах зээл	100%

	нөхцөлийг бүрдүүлэх;				бэлчээрийн удирдлагын хөгжил төслөөс 50 сая төгрөгийн санхүүжилтээр Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх төв байгуулж, гутал засвар, оёдол эсгүүр, эсгийн эдлэл, кофе шоп, давсан бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн чиглэлээр 13 иргэн, аж ахуйн нэгжийг түрээсийн хөнгөлөлт үзүүлэн ажиллав. • Увс аймгийн Тэс, Зүүнговь сумдад ашиглагдахгүй хуучин байрыг ашиглалтад оруулан үйл ажиллагаа явуулж байна. Мөн Өлгий суманд 150 сая төгрөгөөр ахуйн үйлчилгээний төвийг засварлаж үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. • Ховд аймагт “Мянган угалзат” зочид буудлын байрыг бүрэн засварлаж “Шинэ Ховд бизнес инкубатор төв”-ийг байгуулж, үйлчилгээ эрхлэгчдэд үйл ажиллагаа явуулж байна. • Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын хуучин ЗДТГ-ын байрыг 3.9 сая төгрөгөөр засаж ахуйн үйлчилгээний төвийн зориулалтаар ашиглаж байна. Тус төвд оёдолчин, гутал засвар, хэрчсэн гурил үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 8 иргэн ажиллаж байна. • Төв аймгийн Мөнгөнморьт суманд хуучин ЗДТГ-ын байрыг ахуйн үйлчилгээний зориулалтаар, Бүрэн сумны эмнэлгийн зориулалтай байрыг засаж ахуй үйлчилгээний нэгдсэн цэг болгон ашиглаж байна.	
5	4.2.2. Аймаг, нийслэлийн хэрэгцээ, шаардлагад үндэслэн ахуйн үйлчилгээний төвийг шинэчлэх болон шинээр бий болгох;	2020 - 2024	орон нутаг, хувийн хэвшил нийт- 1,548.0 сая.төг		Улсын хэмжээнд 15 ахуйн үйлчилгээний төвийг сум орон нутаг, хувийн хэвшлийн 1548 сая төгрөгөөр хөрөнгө оруулалтаар шинээр байгуулаад байна. Аймаг тус бүрээр авч үзвэл Говь-Алтай аймагт НҮБ-ын ус хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн хөтөлбөрийн дэмжлэгээр Тонхил сумд 251.5 сая төгрөгөөр, Дорноговь аймгийн Даланжаргалан суманд 150 сая төгрөг, Дорнод аймгийн Хэрлэн, Халхгол, Хөлөнбуйр сумдад 195 сая төгрөг, Завхан аймгийн Улиастай суманд 428 сая төгрөг, Өмнөговь аймгийн Манлай, Мандал-Овоо сумдад 229 сая төгрөг, Сүхбаатар аймгийн Баяндэлгэр суманд 17 сая төгрөг, Увс аймгийн Өндөрхангай сум 348 сая төгрөг, Зүүнхангай сум 100 сая төгрөгөөр, Түргэн сум 251 сая төгрөг төгрөг, Хэтийн аймгийн Баянмөнх, Цэнхэрмандал, Мөрөн сумдад ОНХС-с 197,6 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар ахуйн үйлчилгээний төв шинээр ашиглалтад орсон байна.	100%
6	4.2.3. Сум, дүүрэг бүрт халуун усны үйлчилгээг бий болгох;	2020 - 2024	орон нутаг, хувийн хэвшил- 1,821.0 сая төг		Улсын хэмжээнд 12 аймгийн 21 сумдад шинээр 21 халуун усны төвийг 1327 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар бий болгож, 6 аймгийн 11 халуун усны төвийг 494 сая төгрөгөөр шинэчлэн засварлаж үйл ажиллагаа явуулж байна. Архангай аймгийн хэмжээнд 4 сумын халуун усны төвд засвар хийгсэн. Баян-Өлгий аймгийн Бугат суманд 60 сая төгрөгөөр халуун усны төв шинээр ашиглалтад орсон. Баянхонгор аймгийн Хүрээмарал суманд НҮБ-ын төслийн санхүүжилтээр халуун усны төвийг	70%

				<p>шинээр байгуулж, Говь-Алтай аймгийн Жаргалан сумд 82.9 төгрөгөөр халуун усыг шинээр, Эрдэнэ сумд хуучин халуун усыг 79.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар засаж ашиглалтад орууллаа. Дорноговь аймгийн Сайншанд суманд 3 халуун усны төвийг 30 сая төгрөгөөр шинэ халуун усны төвтэй болсон. Завхан аймагийн Яруу, Түдэвтэй, Тэс суманд ОНХСангаас 60.0 сая төгрөгөөр халуун усны төв шинээр бий болсон. Өмнөговь аймгийн Сэврэй, Гурвантэс, Баян-овоо, Баяндалай сумдад 389 сая төгрөгийн орон нутгийн болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар 4 халуун усны төвийг засвар хийгдсэн. Сүхбаатар аймгийн Наран суманд 20 сая төгрөгөөр шинэ халуун усны төвтэй болж, Мөнххаан сумын халуун усны төвийг 5 сая төгрөгөөр засварлаж хэвийн үйл ажиллагаанд оруулсан байна. Сэлэнгэ аймгийн Ерөө сум болон Дулаанхан тосгоны ЕБС-ийн дэргэд Дэлхийн Зөн Монгол ОУБ-ын 450 сая төгрөгөөр ариун цэврийн иж бүрэн (ариун цэврийн өрөө, шүршүүр) төвийг бий болгосон байна. Төв аймгийн Борнуур сумын иргэнд АХС-аас 50.0 төгрөгийн дэмжлэг үзүүлэн шинээр цэг байгуулагдсан. Мөн Зуунмод суманд халуун усны үйлчилгээний 2 цэг шинээр байгуулагдлаа. Ховд аймгийн Алтай, Манхан, Мөст сумдад 450 сая төгрөгөөр халуун усны төв шинээр баригдаж, Дөргөнө сумын халуун усны төвийн засварыг ажил хийгдэж байна. Хэтийн аймгийн Галшир суманд 70 сая төгрөгөөр халуун усны төвүүд баригдаж, шинээр ашиглалтад орсон. Увс аймгийн Түргэн, Баруунтуруун суманд халуун усны газрыг байгуулж, Улаангом сумын Чандмань багт 2 халуун усыг засварлан ажиллуулсан байна.</p>	
7	4.2.4. Аймаг, нийслэлийн хэмжээнд “Ахуйн үйлчилгээний салбарыг хөгжүүлэх хөтөлбөр”-ийг батлуулан, хэрэгжүүлэх;	2020 - 2024		<p>Тус ажлын хүрээнд Ахуйн үйлчилгээний салбарын аймгийн дэд хөтөлбөрийн төслийг боловсруулан аймгуудын ХХААГ-г хүргүүлсэн бөгөөд аймаг тус бүр салбарын нэгдсэн судалгааг гаргаж, Хөвсгөл аймаг ИТХ тэргүүлэгчдийн 2020.09.18-ны өдрийн 91-дугаар тогтоолоор дэд хөтөлбөрийг батлуулан хэрэгжүүлж байна. Бусад аймгуудийн хувьд дэд хөтөлбөрийг аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэхээр бэлтгэсэн боловч 2-р сард дэлхийн хэмжээнд үүсээд буй Covid-19 цар тахлын улмаас улсын хэмжээнд хөл хорио зарласантай холбогдуулан хэлэлцүүлэгдээгүй. Улмаар “Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгыг 2020 оны 05-р сараас мөрдөж эхэлсэн бөгөөд тус хуулиар орон нутагт дэд хөтөлбөр батлах эрх зүйн зохицуулалтгүй болсон тул үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх аймгийн дэд хөтөлбөрийн төлөвлөгөөг боловсуулан ажилласан. Тайлант хугацаанд Говь-Алтай,</p>	70%

				Баянхонгор, Өвөрхангай аймгууд төлөвлөгөөг батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	
8	4.2.5. Төвөөс алслагдсан сум, дүүрэгт явуулын ахуйн үйлчилгээг зохион байгуулах;	2020 - 2024	орон нутгийн төсөв-13.0 сая.төг	Алслагдсан сум, багийн иргэдэд үйлчилгээг ойртуулах, ахуйн үйлчилгээний хүртээмж, үр ашгийг дээшлүүлэх зорилгоор Баян-Өлгий, Говь-Алтай, Говьсүмбэр, Дархан-Уул, Сүхбаатар, Увс, Хэнтий зэрэг нийт 7 аймгийн 21 сумдад явуулын ахуйн үйлчилгээг зохион байгуулсан. Арга хэмжээнд үсчин, гоо сайхан, цахилгаан бараа засвар, гар утас засвар, алт мөнгөний дархан, цаг засвар зэрэг үйлчилгээг нийт 1035 иргэнд хүргэж ажилласан байна. Бусад аймгуудын хувьд 11 дүгээр сард төлөвлөн хийхээр болсон боловч цар тахлын улмаас хийгдээгүй болно.	70%
9	4.2.6. Байгаль орчин, хүний эрүүл мэндэд аюулгүй бүтээгдэхүүн, ахуйн үйлчилгээний нэр төрлийг бодлогоор дэмжих;	2020 - 2024	ЖДҮХС-3,163.0 сая.төг	Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас урт хугацаатай хөнгөлттэй зээл олгох төсөл сонгон шалгаруулах журмын хүрээнд үйлчилгээ эрхлэгчдийг Байгаль орчин, хүний эрүүл мэндэд аюулгүй бүтээгдэхүүн, ахуйн үйлчилгээг хамруулахаар санал тусгагдсан. Тус төсөл сонгон шалгаруулах ажлын хүрээнд 2020 онд үйлчилгээний чиглэлээр 3,163,860,000 төгрөгийн 29 төсөл санхүүжүүлсэн. Төсөл хэрэгжсэнээр 109 ажлын байр хадгалж 264 ажлын байр бий болно.	70%
10	4.2.7. Ахуйн үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгжийг тохирлын үнэлгээнд үе шаттай хамруулах;	2020 - 2024	-	Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 291 дүгээр тогтоолоор батлагдсан Тохирлын баталгаанд заавал хамруулах бүтээгдэхүүн, үйлчилгээний хүрээнд улсын хэмжээнд 2020 онд ахуйн үйлчилгээний салбарын 58 бүтээгдэхүүн үйлчилгээ тохирлын баталгаажуулалтад хамрагдаад байна. Үүнээс нийслэлд 1 саун, 2 гутал засвар, 2 хими цэвэрлэгээ, 2 гоо сайхны бүтээгдэхүүн, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, гэр ахуйн тавилгын 3, оёдлын 7 аж ахуйн нэгж тохирлын гэрчилгээ авсан байна. Орон нутагт халуун ус, үсчин гоо сайхан, авто засварын үйлчилгээг зэрэг 41 үйлчилгээг баталгаажуулалтад хамруулснаар иргэдэд чанар стандартын шаардлага хангасан үйлчилгээ авах нөхцлийг бүрдүүлэн ажилласан байна.	70%
4.3. Төр, хувийн хэвшлийн түншлэлээр бий болсон ахуйн үйлчилгээний төвийн үйлчилгээ эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэх зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.					

11	4.3.1. Ахуйн үйлчилгээ эрхлэгчдийг хөнгөлөлттэй зээл, зээлийн батлан даалтын үйлчилгээнд хамруулах;	2020 - 2024	ХЭДС, СХС, ОНДС болон бусад эх үүсвэрээс 6726.8 сая төгрөг ЗБДС 3,147 сая төгрөг	Ахуйн үйлчилгээ эрхлэгчдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор улсын хэмжээнд нийт 989 аж ахуйн нэгж, иргэнд 6726.8 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлд хамрагдсан байна. Үүнээс СХС-аас 587 төсөлд 4081.8 сая төгрөг, ХЭДС, ОНДС болон бусад төсөл хөтөлбөрөөс 401 төсөлд 2645 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлд ахуйн үйлчилгээ эрхлэгчдийг хамруулж, хөнгөлөлттэй зээл олгон ажилласан байна. Мөн Зээлийн батлан даалтын санд 2020 онд 128 харилцагч 52.1 тэрбум төгрөгийн зээлд 26 тэрбум төгрөгийн батлан даалт гаргуулахаар хүсэлт ирүүлсэн байна. Үүнээс 65 харилцагчийн 24.5 тэрбум төгрөгийн зээлд 12.4 тэрбум төгрөгийн батлан даалт гаргасан байна. Үүнээс үйлчилгээний салбарт 3,147 сая төгрөгийн батлан даалт гаргасан байна.	100%
12	4.3.2. Тогтвортой үйл ажиллагаа явуулж байгаа ахуйн үйлчилгээ эрхлэгчдийг тоног төхөөрөмжийн түрээсийн үйлчилгээ (лизинг)-нд хамруулах;	2020 - 2024	СХС-120.0 сая.төг	Засгийн Газрын 2014 оны 279 тогтоол “Ахуй үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр”, 2014 оны Хөдөлмөрийн сайдын А/221 “Журам батлах тухай” тушаалыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2014 онд сумдад шаардлагатай ахуйн үйлчилгээний тоног төхөөрөмжийг худалдан авах, нийлүүлэх үйл ажиллагааг Сум хөгжүүлэх сангийн санхүүжилтээр 21 аймаг/сумдад/-ын хэмжээнд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ зохион байгуулах тухай хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулсан байна. Худалдан авах ажиллагааны хүрээнд нийлүүлсэн тоног төхөөрөмжийг сумдын хөдөлмөрийн хэлтсээр дамжуулан иргэдэд Сум хөгжүүлэх сангийн хөнгөлөлттэй зээлээр “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам” /Засгийн Газрын 2011 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 134 тогтоол/-ын дагуу жилийн 3 хувийн хүүтэй 36 сар хүртэлх хугацаагаар олгогдсон байна. 2019 оны байдлаар нийт 15 аймаг мэдээлэл ирүүлсэн бөгөөд Архангай, Говьсүмбэр, Завхан, Орхон, Төв, Ховд аймгуудаас мэдээлэл ирүүлээгүй байна. Мэдээлэл ирүүлсэн аймгуудаас Баян-Өлгий*, Баянхонгор, Өвөрхангай, Өмнөговь аймгуудад ахуй үйлчилгээний тоног төхөөрөмж бүрэн олгогдсон байна. Бусад 11 аймгийн 42 сумдад 452 ширхэг тоног төхөөрөмж сумдын Засаг даргын тамгын газрын агуулахад үндсэн бус хөрөнгийн бүртгэлтэй ашиглагдахгүй хадгалагдаж байна. Эдгээр борлуулагдаагүй үлдсэн СХСангийн хөрөнгөөр ирсэн тоног төхөөрөмжийг ахуйн үйлчилгээ эрхлэгчдэд олгох асуулыг зохион байгуулах ажлын хүрээнд: • Архангай: 10 нэр төрлийн гутлын оёдлын машин, олон үйлдэлт ухаалаг оёдлын машин, автомат оёдлын машин, хэрээсний машин, түлхүүр хувилагч хэвтээ, босоо төхөөрөмж, гутал засварын төхөөрөмж, гоо сайхны төхөөрөмж, арьс	70%

				оношлогооны төхөөрөмж зэрэг 120.0 сая төгрөгийн үнэ бүхий 41 ширхэг тоног төхөөрөмжийг 41 ахуй үйлчилгээ эрхлэгчдэд олгосон. Өнөөдрийн байдлаар 395 тоног төхөөрөмжийн үлдэгдэлтэй байна. Цаашид эдгээр тоног төхөөрөмжийг дахин үнэлгээд оруулахаар ажиллаж байна.	
13	4.3.3. Бүтээмж нэмэгдүүлэх, инноваци, байгаль орчинд ээлтэй технологийг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх;	2020 - 2024		2019 онд Нийслэлийн иргэд, олон нийтийн дунд ахуйн үйлчилгээний шинэлэг технологи, инновацыг сурталчилах аяныг нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд зохион байгуулсан. Аяны хүрээнд 5 удаагийн хурал, гэрэл зургийн болон үсчин, гоо сайхны 3 үзүүлэх сургалт зохион байгуулж, 200 гаруй аж ахуйн нэгж, иргэнийг хамруулж, хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр сурталчилсан. Аяны үр дүнд “Грэйт матрикс” ХХК-ийн Матрикс салон, “Си Эс Эл” ХХК-ийн Shoe’s love салон, “Эрчист гялбаа” ХХК-ийн Студи Фото хаус гэрэл зургийн газрын хамт олон шинэлэг технологи нэвтрүүлсэн ААНБ-аар шалгарч, олон нийгэд сурталчиллаа. Мөн тус аяныг амжилттай зохион байгуулсан Сүхбаатар, Баянзүрх, Чингэлтэй дүүргүүдийг “Өргөмжлөл”, мөнгөн шагналгарсан. Тус арга хэмжээг уламжлал болгох зорилгоор Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба болон бусад мэргэжлийн холбоодтой хамтран зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байсан боловч цар тахлын улмаас арга хэмжээ хойшлогдсон.	70%
14	4.3.4. Ахуйн үйлчилгээний чиглэлээр дэлхийн хэмжээний өндөр зэрэглэлийн уралдаан, тэмцээнд амжилттай оролцсон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх;	2020 - 2024		“OMC Hairworld Online Championship” буюу онлайнаар 2020 оны 12-р сард зохион байгуулагдсан. Тус тэмцээнд Монгол Улсыг төлөөлөн Дэлхийн үсчин гоо засалчдын холбооны анхдагч санаачлагчдын мэргэжлийн холбоогоор ахлуулсан нийт 42 хүний бүрэлдэхүүнтэй баг тамирчид амжилттай оролцсон. Тус тэмцээнд оролцох баг тамирчидад дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах зорилгоор Жижиг, дунд үйлдвэрийн газрын даргын 2020 оны А-62 тоот тушаалын дагуу Дэлхийн үсчин гоо засалчдын холбооны анхдагч санаачлагчдын мэргэжлийн холбоотой Хамтран ажиллах гэрээ байгуулж ажилласан.	100%
15	4.3.5. Үйлчилгээний салбарын олон улсын туршлага	2020 - 2024		Ахуйн үйлчилгээний салбарт технологийн дэвшил, инновацийн орчин үеийн ололтыг нэвтрүүлж, салбарын хөгжлийг олон улсын жишигт ойртуулах зорилгоор 2019 онд БНСУ-ын болон Дэлхийн эрүүл мэнд, гоо сайхны холбоо, Монголын үсчин, гоо засалчдын холбоотой хамтран “Бьюти мастер-2019” мэргэжлийн аварга шалгаруулах	100%

	судлахад дэмжлэг үзүүлэх;				тэмцээнийг 19 төрлөөр зохион байгуулж, 200 гаруй үсчин, гоо засалчдыг хамруулсан. Мөн “OMC Hairworld Online Championship” буюу онлайнаар 2020 оны 12-р сард үсчин гоо засалчдын Олон улсын тэмцээн зохион байгуулагдсан. Тус тэмцээнд Монгол Улсыг төлөөлөн Дэлхийн үсчин гоо засалчдын холбооны анхдагч санаачлагчдын мэргэжлийн холбоогоор ахлуулсан нийт 42 хүний бүрэлдэхүүнтэй баг тамирчид амжилттай оролцсон олон улсын туршлага судалсан арга хэмжээ болсон.	
16	4.3.6. Ахуйн үйлчилгээний чиглэлээр бизнес эрхлэгч иргэд, аж ахуйн нэгжийг ажлын байраар хангахад дэмжлэг үзүүлэх.	2020 - 2024			Ахуйн үйлчилгээ эрхлэгчдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор улсын хэмжээнд нийт 989 аж ахуйн нэгж, иргэнд 6726.8 сая төгрөгийн хөнгөлттэй зээлд хамрагдсан байна. Үүнээс СХС-аас 587 төсөлд 4081.8 сая төгрөг, ХЭДС, ОНДС болон бусад төсөл хөтөлбөрөөс 401 төсөлд 2645 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлд ахуйн үйлчилгээ эрхлэгчдийг хамруулж, хөнгөлттэй зээл олгон ажилласан байна. Дээрх төсөл хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр 2020 онд улсын хэмжээнд 1347 ажлын байр шинээр болон хадгалагдсан байна. Үүнээс шинээр 544 ажлын байр бий болж, 763 ажлын байр хадгалагдсан байна.	100%
4.4. Салбарын төрийн болон төрийн бус байгууллага, боловсрол, сургалтын байгууллагуудтай хамтран хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах, давтан сургаж мэргэжил дээшлүүлэх тогтолцоог бүрдүүлж, эрүүл ахуйн зохистой дадлыг нэвтрүүлж, ажиллагсдын тогтвортой хөдөлмөр эрхлэх нөхцөл боломжийг бүрдүүлэх зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.						
17	4.4.1. Ахуйн үйлчилгээний мэргэжилтэй ажилтны чадамжийн үнэлгээ тогтоох, баталгаажуулалтын мэргэшсэн үнэлгээчдийг бэлтгэх;	2020 - 2024	9,985 сая төгрөг		Дотоодын үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч нь МУ-ын Засгийн газрын 2018 оны 291 дүгээр тогтоолоор Тохирлын баталгаанд заавал хамруулах бүтээгдэхүүн, үйлчилгээний жагсаалтад 241 бүтээгдэхүүн, 27 үйлчилгээг хамруулахаар зааж өгсөн. Энэхүү баталгаажуулалтад хамруулснаар Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 101-т заасны дагуу дотоодын үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч нар чанар, стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн, үйлчилгээг төрийн худалдан авалтад нийлүүлэх бүрэн боломжтой болсон. Хуулийн хэрэгжүүлэх ажлын хүрээнд Жижиг, дунд үйлдвэрийн газрын болон аймгуудын Жижиг, дунд үйлдвэр хариуцсан нийт 45 мэргэжилтнүүдэд зориулан “Бүтээгдэхүүн, үйл явц болон үйлчилгээний баталгаажуулалтын аудиторын цахим сургалт” сургалтыг “Эс Эф Си Эс” ХХК-тай хамтран зохион байгуулав. Тус сургалтад хамрагдсан албан хаагчид аудиторын шалгалт өгч тэнцэж холбогдох гэрчилгээ, үнэмлэхийг гардан аваад байна.	100%



18	4.4.2. Ахуйн үйлчилгээ эрхлэгчдийг бизнес, менежментийн зөвлөх үйлчилгээ, сургалтад хамруулах;	2020 - 2024		Хөгжлийн шийдэл ТББ-тай хамтран Нийслэлийн жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдэд зориулсан зөвлөх үйлчилгээг 380 аж ахуйн нэгжид үзүүлсэн. Үүнээс үйлчилгээний чиглэлээр 93 аж ахуйн нэгж хамрагдсан байна. Дэлхий дахинд тархаад буй Коронавируст халдварт өвчнөөс сэргийлж улс орон даяар хорио цээр тогтоосонтой холбогдуулан бизнес эрхлэгчдийг чадавхжуулах зорилгоор онлайнаар зохион байгуулагдсан “Сошиал медиа хөгжүүлэх” сургалтад 29, “Төсөл бичих аргачлал” сургалтад 31, “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан”-ийн зээлийн сургалтад 35 хамрагдсан байна. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн зээлийн бичиг баримт бүрдүүлэх, анхаарах асуудал сургалтад 63, аж ахуй эрхлэлтийн сургалтад 110 хүн, мэргэжил олгох сургалтад 31 хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэргэжил олгох сургалтад 17, хөгжлийн бэрхшээлтэй иргэний аж ахуй эрхлэлтийн сургалтад 54 иргэнийг сургалтад хамруулсан байна.	100%
19	4.4.3. Ахуйн үйлчилгээний ажилтны мэргэжил, ур чадвар олгох ажлыг үе шаттай зохион байгуулах;	2020 - 2024		Мэргэжлийн болон техникийн боловсрол сургалтын байгууллагуудад 2020 оны хичээлийн жилд 18887 суралцагч төгссөн.Төгсөгчдийн 8737 буюу 46.3% нь шууд ажлын байртай, 987 буюу 5.2% нь дараагийн шатны сургалтын байгууллагад дэвшин суралцсан байна. Нийт төгсөгчдөөс 30.2% нь аж үйлдвэрийн салбар, 16.9% нь барилгын салбар, 10.7% нь тээврийн салбар,7.7% нь уул уурхайн салбар,6.9 % нь хөдөө аж ахуйн салбар,6.7% нь үйлчилгээний салбар,4.5% нь мэдээллийн технологийн салбар,4.1% нь соёл урлагийн салбар,4.1% нь эрүүл мэндийн салбар, 2.9% нь байгаль орчны салбар,2.4% нь санхүү, бизнес, худалдааны салбар,0.9% нь эрчим хүчний салбар,0.9% нь Цагдаа, батлан хамгаалах, онцгой байдлын салбар, 0.5% нь хот байгуулалтын салбар, 0.4% нь боловсролын салбар, 0.2% нь шуудан, харилцаа холбооны салбарын мэргэжлүүдээр суралцаж төгссөн байна. Мөн тус арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын Яамны харьяа Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төвтэй хамтран үйлчилгээний салбарын мэргэжилтэй ажилтан бэлтгэх, мэргэшүүлэх, зэрэглэл тогтоох, ур Тус арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын Яамны харьяа Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төвтэй хамтран үйлчилгээний салбарын мэргэжилтэй ажилтан бэлтгэх, мэргэшүүлэх, зэрэглэл тогтоох, ур чадварын үнэлгээ хийх чиглэлээр хамтран ажиллаж, төлөвлөгөө боловсруулан ажил мэргэжлийн лавлах бүхий оёдолчны мэргэжлээр ур чадварын үнэлгээ хийхээр сургалтын хөтөлбөр боловсруулсан. Шинэ	70%

				коронавирусын эрсдэлээс урьдчилан сэргийлэхээр улсын хэмжээнд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан 2020 оны 2 дугаар сараас эхлэн мэргэжлийн сургалтын үйл ажиллагааг зогсоосон. Харин 5 дугаар сараас хөл хориог хэсэгчилэн нээснээр оёдолчны модулын буюу мэргэжлийн ур чадварын үнэлгээ хийх эрх бүхий үнэлгээчний сургалтанд оёдлын холбоодтой хамтран 9 хүнийг хамруулсан.	
20	4.4.4. Ахуйн үйлчилгээний зохистой дадал, ёс зүй, ур чадварыг дээшлүүлэх сургалт зохион байгуулах;	2020 - 2024		Улсын хэмжээнд ахуйн үйлчилгээний чиглэлээр давхардсан тоогоор 3000 гаруй аж ахуйн нэгж, иргэдэд танхимын болон цахим сургалт зохион байгуулагдсан байна. Аймгаар үзвэл: Говьсүмбэр:Салбарын 18 үсчинийг мэргэжил олгох түр сургалтад хамруулж мэргэжлийн үнэмлэхтэй болж ур чадвар эзэмшсэн. Үүнд эрэгтэй 2, эмэгтэй 16 хүн байв. Эдгээр 18 иргэн бүгд ажлын байраар хангагдсан. Сургалтыг “Монголын Экспорт-Импортыг дэмжих” МБСБ хамтран зохион байгуулсан. Дархан:МСҮТ-ийн төвд оёдлын сургалтад 15, Дипломат сургалтын төвд хумс засалч 18 иргэнийг хамруулж чадавхижууллаа. • Орхон: Аймгийн ЗДТГ, Гоо засалчдын холбоотой хамтран ур чадвар, мэргэжил дээшлүүлэх сургалтыг 7 хоногийн хугацаатай зохион байгууллаа. Тус сургалтад сормуусны хими-9, сормуус суулгах-20, WAX-19, маникюр-24 гэсэн 4 төрлөөр давхардсан тоогоор 74 гоо сайханчдыг амжилттай сургаж СЕРТИФИКАТ-тай төгссөн. 20 үсчин, гоо сайханчдад “Стандарт нь бизнесийн амжилтын түлхүүр болох нь” сэдэвт сургалтыг Стандарт хэмжилзүйн хэлтэс, Хөгжлийн шийдэл төрийн бус байгууллагаас хэрэгжүүлж буй BEST хөтөлбөр, Үсчин, гоо засалчдын холбоотой хамтран зохион байгуулсан. Өмнөговь:BIG сургалтын төв, Татварын хэлтэс, Стандарт хэмжил зүйн хэлтэй, МХГазар, НДХэлтэй, ХХҮГазар зэрэг төрийн байгууллагуудтай хамтран 6 удаагийн сургалтыг зохион байгуулсан. Сургалтад давхардсан тоогоор 417 иргэн аж ахуйн нэгж хамрагдаж мэргэжил дээшлүүлэн оролцлоо. Мөн Гурван тэс сумын Тостын оргил ХХК-ний Сөөхий гутлын цехийн үйлдвэрлэл эрхлэгч 1 иргэн улсын болон гадны ижил төрлийн үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчдээс туршлага судалж, мэргэжил дээшлүүлсэн, Ханбогд сумын 2 иргэн гоо сайхны сургалтанд сууж мэдлэг ур чадвараа дээшлүүлсэн, Даланзадгад сумын 15 иргэн мөн үсчин гоо сайхны чиглэлээр ахисан шатны сургалтанд хамрагдаж амжилттай төгссөн байна.	100%
21	4.4.5. Салбарын хэмжээнд ажиллаж	2020 - 2024		Говь-Алтай: Орон нутгийн баялаг бүтээгчдийн үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор “Алтайд үйлдвэрлэв” дэлгүүрийг Тэнгис-Алтай ХХК, Алтай нисэх буудалд тус тус	70%

	байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг олон нийтэд сурталчлах, борлуулах цэг бий болгоход төрөөс дэмжлэг үзүүлэх;			ажиллуулан тэдний үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг үйлдвэрийн үнээр борлуулах, сурталчлан таниулах үйл ажиллагааг ХХҮГазартай хамтран зохион байгуулж байна. Тус дэлгүүрээр нийт 17 аж ахуйн нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгчид бараа бүтээгдэхүүнээ борлуулж байна. Дээрх дэлгүүрүүдийн түрээсийн төлбөрт 5220.0 мянган төгрөгийн дэмжлэгийг ХЭДСангаас үзүүлсэн байна. Баянхонгор: Цахим худалдаа “Баянхонгор-Үйлдвэрлэв” facebook хуудсыг ашиглалтад оруулж, хөнгөн, жижиг, дунд үйлдвэр, ахуйн үйлчилгээ эрхлэгчдийн үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээний танилцуулгыг холбогдох утасны дугаарын хамт байршуулан, иргэд олон нийтэд дэлгэрэнгүй мэдээлэл өгч, үйлдвэрлэгч-худалдан авчдыг холбон цахим худалдааг амжилттай ажиллуулж байна. Энэхүү facebook хуудсанд 11 сумын 50 жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн 100 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүнийг байршуулан, төрөөс авч хэрэгжүүлж буй бодлого шийдвэр, зохион байгуулагдах сургалт, зөвлөгөөн, уулзалт, хөнгөлөлттэй зээл, тусламжуудын талаар мэдээллийг байнга шинэчлэн байршуулан ажиллаж байна. Говьсүмбэр: Аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоотой хамтран салбарын хэмжээнд ажиллаж байгаа 9 хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн судалгааг гарган, 8 иргэнд 26.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг сурталчлан Говьсүмбэрт үйлдвэрлэв борлуулах цэгт үнэ төлбөргүй байршуулан борлуулах ажлыг зохион байгуулсан. Дорнод: Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын албан ёсны хуудсаар дамжуулан хөгжлийн бэрхшээлтэй иргэн О.Наранцэцэг нь эсгийгээр бүтээгдэхүүнээ зарж борлуулж байна. Ховд: Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газартай хамтарч салбарын хэмжээнд ажиллаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй 12 иргэдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг олон нийтэд сурталчилж, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний төвд борлуулах цэг бий болгон дэмжиж ажлын байртай болгосон.	
22	4.4.6. Өнчин болон хөгжлийн бэрхшээлтэй хөдөлмөрийн насны залуусыг ахуйн үйлчилгээний салбарт ажиллах	2020 - 2024	ХЭДС- 321.5 са.төг	Ахуйн үйлчилгээний салбарт Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас Архангай, Баян-Өлгий, Дархан-Уул, Орхон, Хэнтий аймагт хөгжлийн бэрхшээлтэй 86 иргэнд 321,5 сая төгрөгийн хөнгөлттэй зээлийн олгосноор 14 ажлын байр шинээр бий болсон байна. Бусад аймгуудын хувьд: <ul style="list-style-type: none"> <li>Говьсүмбэр: Бүрэн Урлан ХХК-ийн ажил олгогчтой гэрээ байгуулан 1.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэн хөгжлийн бэрхшээлтэй 2 иргэнийг тусгайлан байнгын ажлын байр ханган ажиллуулж байна.</li> </ul>	100%

	боломжийг дэмжих;			<ul style="list-style-type: none"> <li>• Увс: Хөгжлийн бэрхшээлтэй 2 иргэнийг гэрэл зураг, оёдол засварын чиглэлээр СХСангийн зээлээр дэмжин ажиллалаа. Ахуйн үйлчилгээний чиглэлээр эмзэг бүлгийн 30 гаруй иргэдэд үнэ төлбөргүй үйлчилгээ үзүүлсэн.</li> <li>• Ховд: Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газартай хамтарч өнчин болон хөгжлийн бэрхшээлтэй хөдөлмөрийн насны 5 залуусыг ахуйн үйлчилгээний салбарт ажиллах “Бизнес инкубатор төв”-д оёдлоор болон модны мужаанаар ажиллах боломжоор дэмжин ажлын байр гарган өгч ажиллуулж байна. Мөн Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газраас Нийслэлийн хэмжээнд нийт 21 ажил олгогчтой хамтран 13 удаагийн ажлын байрны өдөрлөг зохион байгуулсны үр дүнд давхардсан тоогоор 100 гаруй ажил олгогчийн 3553 ажлын байр зарлагдаж, 1230 иргэнийг ажлын ярилцлагад хамруулснаас 332 иргэн ажилд орж, 252 иргэн нөөцөд бүртгэгдсэн байна.</li> </ul>	
23	4.4.7. Салбарын хэмжээнд туршлага солилцох, ажил, мэргэжлийн уралдаан, тэмцээнийг төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулах;	2020 - 2024		Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба Монголын үсчин, Гоо засалчдын Холбоотой хамтран “Нийслэлийн аварга шалгаруулах үсчин, гоо засалч, хумс засалчдын ажил мэргэжлийн уралдааныг 2019 онд 10 дахь жилдээ зохион байгуулсан. Тус тэмцээнийг Монголын Үсчин, Гоо засалчдын Холбоо нь нийслэлийн иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн үсчин, гоо сайхны үйлчилгээний шинэ технологийг сурталчилах, харилцан суралцах, үйлчилгээнд нэвтрүүлэх зорилготой юм. Нийслэлийн болон улсын аварга шалгаруулах тэмцээнийг уламжлал болгон 2 жилд нэг удаа зохион байгуулдаг бол 2020 онд Улсын аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулахаар төлөвлөсөн боловч Дэлхий нийтээр үүсээд буй цар тахлын улмаас арга хэмжээг зохион байгуулагдаагүй.	70%
24	4.4.8. Ахуйн үйлчилгээ эрхлэгчдийг мэдээллээр хангах, мэргэжлийн зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлэх;	2020 - 2024		Хөгжлийн шийдэл ТББ-тай хамтран 2020 оны 4 сард 21 аймгийн мэргэжилтнүүдийг чадвахижуулах цахим сургалтыг зохион байгуулав. Тус сургалтаар Ахуйн үйлчилгээний салбарын бодлого, хөтөлбөрийг танилцуулав. Мөн 2020 оны 12 сарын 30-ны өдөр цахимаар Ахуйн үйлчилгээний салбарын 2020 онд хийсэн ажил болон цаашид анхаарах асуудлаар 21 аймгийн мэргэжилтнүүдэд мэдээлэл хийж ажиллав. Хэнтэй: "Ахуйн үйлчилгээний салбарыг хөгжүүлэх Үндэсний хөтөлбөрийн хүрээнд: "Нийтийн аж, ахуй үйлчилгээний салбарын ажилчдын өдөр"-ийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд Жижиг дунд үйлдвэр эрхлэгчид болон Ахуйн үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулж байгаа иргэдийн бүтээгдэхүүн, үйлчилгээг олон нийтэд сурталчлан таниулах, урамшуулах ур чадварыг нь дээшлүүлэх, туршлага судлах зорилгоор "АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭ-2020" өдөрлөгийг	90%

				10 сарын 16-ны өдөр амжилттай зохион байгуулж шилдэгээ тодрууллаа.Өдөрлөгт 8 сумын 50 гаруй иргэн, Аж ахуй нэгж оролцож бүтээгдэхүүн үйлчилгээгээ сурталчлан ажилласан. Дорнод: Засаг даргын 2020 оны А/53 дугаар захирамжын дагуу "Ахуйн үйлчилгээний салбарын хөгжил-2020" аяны нээлтийн үйл ажиллагааг 2020 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр зохион байгуулсан. Нээлтийн үйл ажиллагаанд аймгийн Засаг даргын орлогч Ч.Ганбат, аймгийн ЗДТГ-ын ХОХБТХэлтэсийн дарга Х.Бат-Эрдэнэ нар нээж үг хэлж, сумын ХААТасгийн мэргэжилтнүүдэд үүрэг чиглэл өгсөн. "Ахуйн үйлчилгээний салбарын хөгжил-2020" аян 2020 оны 11 дүгээр сарын 10-ны өдрөөс Баян-Уул сумаас эхлэн зохион байгуулахаар төлөвлөсөн боловч корона вирус ковид-19 цар тахал Монгол улсад дотооддоо халдварласаны улмаас хойшлогдоод байна.	
25	4.4.9. Албан бус хөдөлмөр эрхлэгчдийг бүртгэж, төр, иргэний нийгмийн байгууллага, мэргэжлийн холбоодын оролцоотойгоор нийгмийн үйлчилгээнд хамрагдах боломжийг нэмэгдүүлэх.	2020 - 2024	ХЭДС-3.3 сая.төг	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор "Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр" батлагдсан. Тус хөтөлбөрийн хүрээнд 7 аймагт ядуу өрхийн багаас доош боловсролтой 15 иргэнийг оёдолчин, гоо засалч-маникюр, цахилгаанчин, хүнд машин механизмын операторчин зэрэг мэргэжлүүдээр мэргэжлийн сургалтад хамруулж 3,338,000 төгрөгийг зарцуулсан байна. Тус сургалтад хамрагдсан иргэдээс 7 иргэн байнгын ажлын байраар хангагджээ. Мөн Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газар нь Нийслэлийн хэмжээнд нийт 21 ажил олгогчтой хамтран 13 удаагийн ажлын байрны өдөрлөг зохион байгуулсны үр дүнд давхардсан тоогоор 100 гаруй ажил олгогчийн 3553 ажлын байр зарлагдаж, 1230 иргэнийг ажлын ярилцлагад хамруулснаас 332 иргэн ажилд орж, 252 иргэн нөөцөд бүртгэгдсэн байна.	70%
4.5. Ахуйн үйлчилгээний салбарын мэдээллийн сан бүрдүүлэх зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.					
26	4.5.1. Ахуйн үйлчилгээний салбарын статистик мэдээлэл цуглуулах, боловсруулах	2020 - 2024		Нийслэлийн ахуйн үйлчилгээний салбарын статистик мэдээллийн системийг хөгжүүлж, мэдээллийн сан бүрдүүлэх зорилтыг хэрэгжүүлэхээр Үндэсний статистикийн хорооны даргын 2019 оны А/174 дүгээр тушаалаар зөвшөөрсөн захиргааны статистикийн мэдээллийн маягтыг батлах тухай захирамжийн төсөл боловсруулж, холбогдох албан тушаалтнуудаас санал авч, Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/120 дугаар захирамж батлууллаа. ХЕМ-ийн 2020 оны А/46 дугаар	90%

	тогтолцоог бүрдүүлж, үндэсний статистикийн бүрэлдэхүүнд ахуйн үйлчилгээний салбарын бүлэг үзүүлэлтийг оруулах асуудлыг судалж, шийдвэрлэх;			тушаалаар ахуйн үйлчилгээний салбарын статистикийн мэдээллийн батлагдсан маягтыг хэвлэх зардлыг батлуулан хэвлэж, ахуйн үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг иргэн, аж ахуйн нэгжийн тоогоор дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлж, эхний хагас жилийн мэдээг 2020 оны 7 дугаар сарын 25-ны дотор ирүүлсэн. Судалгааны UBSurvey программын эрхийг авч, маягтыг шинээр боловсруулж оруулан, цахимаар авах бүрэн боломжтой болж, нийт 1921 ахуйн үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжийн судалгааг аваад байна.	
27	4.5.2. Улсын хэмжээнд ахуйн үйлчилгээний салбарын мэдээллийн нэгдсэн сан, цахим хуудсыг шинээр бий болгох;	2020 - 2024		Тус ажлын хүрээнд Ахуйн үйлчилгээний салбарын нэгдсэн мэдээллийн санг үүсгэх маягт боловсруулав. Тус маягтын дагуу улсын хэмжээнд нэгдсэн судалгааг зохион байгуулахаар бэлтгэл ажлын ханган ажиллаж байна. Орон нутгийн хэмжээнд: Баян-Өлгий: Тус аймгийн хэмжээнд нийт 245 иргэн, аж ахуйн нэгж ахуйн үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулж, 405 хүн тус салбарт ажиллаж байна. Баянхонгор: Аймгийн хэмжээнд ахуйн үйлчилгээний 20 төрлөөс айл гэр, албан байгууллага цэвэрлэх үйлчилгээ болон нүүлгэх үйлчилгээ гэсэн 2 үйл ажиллагаа огт явуулдаггүй. Бусад 18 үйлчилгээнд 400 үйлдвэрлэл эрхлэгч үйл ажиллагаагаа тогтмол явуулж, 524 хүн ажиллаж байна. Энэ онд ахуйн үйлчилгээний салбарын 46 төсөлд 317,0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгосноор шинээр 69 ажлын байр гарсан үзүүлэлттэй байна. Говь-Алтай: Ахуйн үйлчилгээний чиглэлээр нийт 464 иргэн ажиллаж байна. Тус аймгийн хамгийн хэмжээнд 6 ахуйн үйлчилгээний төв, 26 халуун ус ажиллаж байна. Говьсүмбэр: Ахуйн үйлчилгээний цэг-1, Халуун усны төв -2, Ахуйн үйлчилгээний салбарын ажилтны тоо-115 үүнээс /мэргэжлийн-60, мэргэжлийн бус-68/, Сумдаар харуулбал: Сүмбэр сум-49 ахуй үйлчилгээ эрхлэгч, Шивээговь сум-6, Баянтал сум-6/ байна. Дархан: Ахуйн үйлчилгээний салбарын шинэчлэн гаргасан судалгаагаар аймгийн хэмжээнд үсчин гоо сайхан-48, хувцас захиалга-107, гутал-27, хими-2, цахилгаан-16, модон эдлэл-11, цоож түлхүүр-5, алт мөнгөний дархан-3, гэрэл зураг-7, халуун ус-10 нийт 236 ахуйн үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж ахуйн үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байна.	70%